



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/65

Мандалговь

**“Ашид бьюлдинг” ХХК-тай гэрээ байгуулах
тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын тамгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/22 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Эрдэнэдалай сумын Сургуулийн дотуур байрны засварын ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюлдинг” ХХК-тай 116,767,658 (нэг зуун арван зургаан сая долоон зуун жаран долоо мянга зургаан зуун тавин найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Эрдэнэдалай сумын Сургуулийн дотуур байрны засварын ажил”-ыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюлдинг” ХХК-ны захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060266